

ШИНЖЭЭЧ СОНГОХ УРИЛГА

1. Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газар нь төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8 дахь заалт, Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, 8.7 дахь заалтыг тус тус үндэслэн Таван толгой ХК-ны 2020 оны санхүүгийн тайлангийн аудитыг гэрээний үндсэн дээр гүйцэтгэх аудитын хуулийн этгээдийг сонгон шалгаруулах тул хураангуй жагсаалтад орсон аудитын хуулийн этгээдүүд саналаа ирүүлэхийг урьж байна.

Зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулах ажлын даалгаврыг үндэслэн Саналын жишиг баримт бичгийг маягтын дагуу бүрдүүлж саналаа ирүүлнэ үү.

Бүлэг 1 – Урилга

Бүлэг 2 – Ажлын даалгавар

Бүлэг 3 – Саналын жишиг баримт бичиг

Бүлэг 4 – Гэрээний ерөнхий, тусгай нөхцөл

2. Нэмэлт мэдээллийг авах хүсэлтийг санал ирүүлэх хугацаанаас ажлын 2 хоногийн өмнө албан бичгээр ирүүлнэ.

3. Саналаа битүүмжлэн дор дурдсан хаягаар 2021 оны 02 дугаар сарын 19-ны өдрийн дотор цаасаар болон цахим хэлбэрээр ирүүлнэ үү.

Хаяг: Өмнөговь аймаг, Даланзадгад сум

3-р баг Нутгийн удирдлагын ордон 303 тоот

Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газар

Харилцах албан тушаалтан: С.Одончимэг

Утасны дугаар: 70533552, 89008029

Мэйл хаяг: Umnugovi@audit.gov.mn